

1913 ОНЫ ТАВАН ЗАМЫН ЦЭРГИЙН ТҮҮХИЙН ЗАРИМ АСУУДАЛД

Б.БАТСҮРЭН

Товч агуулга: 1911 онд тусгаар тогтнолоо сэргээсэн Монгол улс 1913 онд өөрийн улсын хил хязгаарт цөмөрч байрласан Дундад иргэн улсын цэрэгтэй бараг жилийн турш байлдсан билээ. Эх орны түүх бичлэгт тухайн үйл явдлыг хэрхэн үнэлж бичдэг талаар эл өгүүлэлд дурдаад өөрсдийн саналыг хэлэв.

Түлхүүр үг: Таван зам, дайн, байлдаан, шинж чанар.

Эртний уламжлалт хаант засагтай улсаа сэргээсэн монголчууд 1912 оноос эхлэн өмнөд монголчуудын нутаг 49 хошуу, Хөх хот, Долоннуур зэрэг чухал чиглэлээр Монголын нутаг дэвсгэрт цэрэглэн халдах болсон Дундад иргэн улсын үйл ажиллагааг түрэмгийлэл хэмээн үзэв. Тиймээс Монголын төрх цэргийг таван замд анги хуваан мордуулж, газар орныг сэргийлэн хамгаалуулж, чанагш улмаар давшуулан дайсны цэргийг тосон дайлж, нэгэн сэтгэл хүчнээр байлдан сөнөөж газар орныг ариутган тохинуулахаар¹ 1913 оны эхээр шийдвэрлэж улмаар оны төгсгөл хүртэл Дундад иргэн улсын цэрэгтэй жар, дал гаруй удаа тулалджээ. Тус өгүүлэлд 1913 оны энэхүү түүхэн үйл явдалд холбогдох ганц нэг асуудлыг хөндөж өөрсдийн саналыг хэлэхийг оролдоё.

XX зууны хоёрдахь арван жилийн Монголын түүхийг нэгтгэн өгүүлсэн “Монголын автономит үеийн түүх” хэмээх бүтээлдээ Ц.Пунцагноров 1913 онд таван замаар цэрэглэн Өвөрмонголд халдсан хятад цэрэгтэй тулалдсан түүхэн үйл явдлыг хамгийн анх “Өвөр Монголд явуулсан чөлөөлөх дайн”² хэмээн нэрлэсэн бол 1968 онд хэвлэгдсэн БНМАУ-ын түүхийн дэд ботид “Өвөр Монголыг чөлөөлөх хөдөлгөөн ... Өвөр Монголд явагдсан байлдаан”³ гэж тус үйл явдлыг тодорхойлжээ. Үүнээс хойш 1913 оны түүхэн үйл явдлыг их төлөв байлдаан хэмээн тодорхойлж ирсэн мэт. Тухайлбал, 1911-1921 оны Богд хаант Монгол улсын цэргийн асуудлыг хөндөж судалсан С.Гангааням тус үйл явдлыг “таван замын цэргийн байлдаан ...

¹ *Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл.* Баримт бичгийн эмхтгэл (1911-1914). Эмхтгэсэн А.Очир, Г.Пүрэвээ, тайлбар бичсэн А.Очир. Улаанбаатар: 1982, 223, 224, 226

² Пунцагноров Ц. *Монголын автономит үеийн түүх.* Улаанбаатар: 1955, 63

³ *БНМАУ-ын түүх.* Дэд боть (1604-1917). Улаанбаатар: 1968, 480

Өвөрмонголд болсон байлдаан” хэмээн үзсэн бол 1996 онд хэвлэгдсэн “Монгол цэргийн түүхийн товчоон” хэмээх хоёр боть зохиолын дэд ботид “Өвөр Монголыг чөлөөлөхийн төлөө хийсэн байлдаан”⁴ гэж таван замаар мордож ДИУ-ын зэвсэгт хүчинтэй бараг бүтэн жил зэвсэгт мөргөлдөөн хийсэн монгол цэргийн үйл ажиллагааг тодорхойлсон байдаг.

Түүнчлэн 2001 оны эхэнд хэвлэгдсэн “Хорьдугаар зууны Монгол цэрэг” гэсэн хамтын бүтээлд “... монгол цэргийн томоохон операцийн нэг бол түүхнээ “Таван замын байлдаан” хэмээн тэмдэглэгдсэн Өвөр Монголыг чөлөөлөх байлдааны ажиллагаа юм” гэж дурджээ. Сонирхолтой нь тус бүтээлд “... 1913 оны ... түүхнээ <Таван замын байлдаан> хэмээн тэмдэглэгдсэн аян дайн дуусчээ” гэсэн нэг өгүүлбэр бас бий. Үүнээс гадна дашрамд өгүүлэхэд “манжийн ноёрхлыг түлхэн унагасан монголчуудын тэмцэл нь: нэгдүгээрт: фронтын тасралтгүй үргэлжилсэн шугамгүй; хоёрдугаарт: Монгол улсын бүхий л нутаг дэвсгэрийг хамарсан шинжтэй агаад, фронт, ар талын тодорхой ялгаа, зааггүй; гуравдугаарт: байлдааны гол ажиллагаа голомтын чанартай төвүүдэд болсноороо онцлог бөгөөд орчин үеийн ойлголтоор бол “жижиг дайн”-ы шинжтэй ч гэмээр байсан байна” гэж энэхүү бүтээлд тэмдэглэжээ.⁵

1911 оны Үндэсний хувьсгалын ялалтын түүхт 100 жилийн ойд зориулж эмхтгэн 2011 онд хэвлэсэн “Монголын үндэсний хувьсгалын нэвтэрхий толь”-д “Өвөр Монголыг чөлөөлөх Таван замын цэргийн үйл ажиллагаа ...”⁶ хэмээн бичжээ.

Харин тэртээ 1955 онд Ц.Пунцагноровын хэлсэн “дайн”, түүний дотор “чөлөөлөх дайн” гэсэнтэй адил саналыг Д.Гомбосүрэн, 2001 оны 12 дугаар сарын 14-нд болсон Үндэсний хувьсгалын 90 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлдээ “үндэс гарвал нэгтэй өвөрлөгч, барга зэрэг ах дүү нараа ДИУ-ын дарлалаас чөлөөлж, монгол үндэстнийг нэгтгэхийн төлөө явуулсан аян дайн байлаа” хэмээн өгүүлсэн байна.⁷

Бид ч мөн 2001 оны 12 дугаар сарын 21-нд болсон “Монгол улсад батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үүсэн байгуулагдсаны 90 жилийн ой”-д зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн илтгэлдээ иймэрхүү санал дэвшүүлсэн. Түүнд, таван замаар Дундад

⁴ *Монгол цэргийн түүхийн товчоон* (1911 оноос 1990 – ээд он). Дэд дэвтэр. Улаанбаатар: 1996, 82

⁵ *Хорьдугаар зууны Монгол цэрэг*. Улаанбаатар: 2001, 201, 202-203

⁶ *Монголын үндэсний хувьсгалын нэвтэрхий толь (1911-1921)*. Улаанбаатар: 2011, 309

⁷ Гомбосүрэн Д. *Олноо өргөгдсөн Монгол улсын цэрэг*. Монголын үндэсний хувьсгалын түүхийн асуудал. Эрхэлсэн Ж.Болдбаатар, Г.Дашням, Н.Хишигт. Улаанбаатар: 2002, 139

иргэн улсын цэрэгтэй 1913 онд дайтсан явдал нь “ХХ зуунд монголчуудын үзэж өнгөрүүлсэн анхны томоохон дайн байж болох юм”⁸ хэмээн бичсэн зүйл бий.

Өвөрмонголд Дундад иргэн улсын цэрэгтэй зэвсэгт мөргөлдөөн явуулсан 1913 оны үйл явдал бол дайн байсан гэж үзэгч эрдэмтдийн бичснээс харвал бас дотроо бага зэргийн ялгаатай байна. Тухайлбал:

Ц.Пунцагноров – Өвөр Монголд явуулсан чөлөөлөх дайн (1955 он);

Ж.Базарсүрэн – Өвөр Монголыг чөлөөлөхийн төлөө хийсэн аян дайн (2001 он);

Д.Гомбосүрэн – Монгол үндэстнийг нэгтгэхийн төлөө явуулсан аян дайн (2001 он);

Б.Батсүрэн – анхны томоохон дайн (2001, 2007);

Г.Мягмарсамбуу – 1913 оны Өвөр Монголыг чөлөөлөх дайн (2012) гэж бичсэн байна.

Ийм саналтай өөрөөр хэлбэл, 1913 онд Дундад иргэн улстай дайтсан түүхэн үйл явдлыг дайн байжээ гэсэн саналыг дэмжигчид сүүлийн үед нэмэгдэх хандлагатай болжээ.⁹

Тийм боловч эдгээр судлаач (Ц.Пунцагноров, Ж.Базарсүрэн, Д.Гомбосүрэн, Г.Мягмарсамбуу) чухам юуны учир дайн гэж үзэх болсон шалтгаанаа, тухайн түүхэн үйл явдалд ямар ямар шинж чанар байгаа учраас дайн хэмээн үзэх харж болох талаар тодорхой тайлбар бараг дурдаагүй байдаг. Магадгүй бид олж үзэж чадаагүй байж болох юм.

Гэхдээ тухайн саналыг дэмжигчдийн зарим нэг нь юуны учир 1913 оны түүхэн үйл явдлыг дайн хэмээх үзэх болсон талаар жижигхэн санал дэвшүүлж байсан билээ.¹⁰

Ийнхүү сүүлийн үед судлаачид Монгол улсаас 1913 онд Дундад иргэн улстай хийсэн зэвсэгт мөргөлдөөнийг дайн гэж үзэх хандлага нэмэгдэж байгаа ч, Таван замын цэргийн явуулсан тус үйл ажиллагааг дайн биш гэж үзэх явдал ч хэвээр байна. Жишээлбэл, 2013 оны 11 дүгээр сарын 12-нд Богд хааны ордон музейн хурлын танхимд болсон “Таван замын байлдаан – 100 жил: түүх, судалгаа” сэдэвт

⁸ Батсүрэн Б. Таван замын цэрэг. *Эрдэм шинжилгээний бага хурлуудын эмхтгэл*. №1. Эмхтгэж хянан тохиолдуулсан С.Ганболд. Улаанбаатар: 2006, 199

⁹ Мягмарсамбуу Г. *Монгол улсын цэрэг, цэргийн жанжид (ХХ зууны эхэн)*. Дөтгөөр дэвтэр. Цэргийн жанжин Манлай баатар Жамсрангийн Дамдинсүрэн 1871-1921 (Түүх, угсаатны зүйн судалгаа). Улаанбаатар: 2012, 119

¹⁰ Батсүрэн Б. Дундад иргэн улсын цэрэгтэй “Таван замаар” дайтсан тухай. - *1911 оны үндэсний хувьсгал ба VIII Богд Жибзундамба хутагт (Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл)*. Эрхэлсэн академич Ж.Болдбаатар, доктор (Ph.D) Д.Сүхбаатар. Улаанбаатар: 2007, 144

эрдэм шинжилгээний хуралд оролцож үг хэлсэн, чөлөөнд байгаа генерал Б.Шагдар, ХХЕГ-ын Хилийн түүх судлалын секторын дарга хурандаа Ж.Өвгөнбүргэд нарын зарим цэргийн судлаач тус түүхэн үйл явдлыг дайн хэмээн үзэх боломжгүй гэсэн саналыг хэлсэн билээ.

Тиймээс эх орны түүх судлалын судлах ёстой нэг чухал сэдэв болсон 1913 оны уг түүхэн үйл явдал нь агуулга, шинж чанараараа «дайн» эсвэл «байлдаан», эсвэл «операци» байсан эсэхийг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай нь харагдах байх.

Эн тэргүүнээ монгол хэлний тайлбар толиудад зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой нэр томъёог хэрхэн тайлбарласан талаар эхлээд сонирхье.

“Монгол хэлний товч тайлбар толь”-д тулалдаан, байлдаан, дайн гэсэн гурван үгийг дараах байдлаар тайлбарлажээ. Нэгд, тулалдаан (tululduyan)-ыг энэ тайлбар тольд “... дайсантай нүүр учирч тулалдах нь” хэмээн тодорхойлсон бол байлдаан (bayiluyan)-ыг “бага хэмжээний газар хамарсан зэвсэгт тулалдаан” хэмээн тайлбарлажээ.¹¹ Харин дайн (dayin)-ыг улс болон нийгмийн анги бүлгүүдийн хоорондоо хийх зэвсэгт тэмцэл гэжээ.¹²

Тухайн тайлбараас үзвэл тулалдаан нь хэмжээний хувьд багавтар зэвсэгт мөргөлдөөн болох харагдах ба магадгүй зарим тохиолдолд хоёр этгээд ч нүүр тулж тэмцэлдэхийг ийнхүү тулалдах, тулалдаан гэсэн үгээр илэрхийлж болох нь.

Байлдааны хувьд нэг ойлголт нэмэгдэж байгаа газар орон гэсэн ухагдахуун хэмээн бид ойлгож байна. Өөрөөр хэлбэл, тухайлсан нэг газар бус харин тодорхой хэмжээний гэхдээ өргөн уудам бус нутаг дэвсгэрийг хамарсан зэвсэгт мөргөлдөөнийг байлдаан хэмээдэг бололтой.

Гэтэл Таван замаар Дундад иргэн улсын цэрэгтэй зэвсэг зөрүүлсэн мөргөлдөөн нь зүүнээс баруунаа 1000 шахам км, хойноос урагшаа гүнээрээ 140-480 орчим км өргөн уудам газрыг хамарсан бүс нутагт болж өнгөрсөн. Хэрвээ баруун хязгаарт өрнөсөн зэвсэгт мөргөлдөөнийг энэ дайны нэг хэсэг гэж авч үзвэл лавтай дээр өгүүлсэн байлдааны тодорхойлолтой тохирохгүй байна. Тиймээс дайн гэж үзэх бүрэн бололцоотой.

Монгол хэлний тайлбар толийн дайны талаарх тодорхойлолт нь Монгол улсаас “их цэргийг таван замд анги хуваан мордуулж, газар орныг сэргийлэн хамгаалуулж, ... чанагш улмаар давшуулан дайсны цэргийг тосон дайлж, ... нэгэн сэтгэл хүчнээр байлдан сөнөөж газар орныг ариутган тохинуулахаар”

¹¹ Цэвэл Я. *Монгол хэлний товч тайлбар толь*. Нэмж дэлгэрүүлсэн хоёрдугаар хэвлэл. Үг, утга, жишээ, тайлбар, хавсралт тэргүүтнийг нэмж хянасан Ц.Шагдарсүрэн. Улаанбаатар: 2013, 765, 83

¹² Мөн тэнд, 253

шийдвэрлэж эхлүүлсэн 1913 оны цэрэг-байлдааны үйл ажиллагаатай үндсэндээ тохирно. Хамгийн ерөнхий тодорхойлолтоор гэхэд дайныг – улс орон, овог, аймаг гэх мэт тодорхой улс төрийн бүрдлүүдийн хооронд зэвсэгт тэмцлийн хэлбэртэй, зэвсэгт хүчнүүдийнх нь хооронд явагддаг дайн, байлдаан байдлаар илэрдэг мөргөлдөөн гэж хэлдэг. Тэгээд ч Карл фон Клаузевицийн “дайн бол улс орны бодлогыг өөр арга хэрэгсэлээр үргэлжлүүлж байгаагаас өөр юу ч биш”¹³ гэж хэлсэн тодорхойлолт өнөөдөр ч үнэнтэй хэвээр байгаа. Карл фон Клаузевицийн дайны тухай тодорхойлолтыг дэмждэг Карл Бернхард фон Мольтке бээр, би дайныг улс орны тусгаар тогтнол, оршихуйн төлөөх хамгийн сүүлчийн гэхдээ хууль ёсны арга хэрэгсэл гэж үзнэ хэмээгээд нэмж, орчин үеийн дайн бүх ард түмнийг зэвсэг барихыг шаардаж байна гэж бичжээ.¹⁴ Харин 1992 онд хэвлэгдсэн “Цэргийн шинжлэх ухаан. Онолын асуудал” гэсэн бүтээлд дайны талаар дараах тодорхойлолтыг өгчээ. Үүнд, “Дайн бол нарийн түвэгтэй нийгэм-улс төрийн үзэгдэл мөн. Дайн нь нийгмийн байгуулал, анги, үндэстэн, улс гүрнүүд өөр хоорондоо сөргөлдөж, зэвсэгт хүчирхийлэл ашиглаж өөрсдийн тавьсан улс төрийн зорилгодоо хүрэх үйл ажиллагааг хэлнэ.”¹⁵

Ийм боловч 1913 оны түүхэн үйл явдал нь үнэхээр дайны шинж чанартай байсан гэдгийг өөр олон баримт судалгаагаар харуулах хэрэгтэй. Ганц нэг тодорхойлолтоор асуудлыг шийдвэрлэх аргагүй, тэгээд ч энэ нь эргээд аргагүйн алдаа болох магадлал ихтэй.

Цэрэг-дайны түүх, цэргийн үйл хэргийг судалдаг эрдэмтдийн бичсэнээр бол аливаа нэгэн зэвсэгт мөргөлдөөнийг дайн гэж үзэхэд дараах хэдэн шалгуур гэмээр зүйл түүнд агуулагдаж байх ёстой мэт. Үүнд:

нэгд, зорилго бий эсэх,

хоёрт, дайн, байлдаанд зориулсан хөрөнгө сүйтгэл, түүний эдийн засагт эзлэх хувь,

гуравт, байлдаж буй цэрэг-армид алба хаагч хүмүүсийн тоо хэмжээ гэх мэт хэдэн зүйлийг нэрлэж болох юм.

Монголчууд 1913 онд юуны төлөө зэвсэг барьж ДИУ-тай тэмцэлдсэн зорилгыг бүгдээрээ мэдэх тул давтаж нуршилгүй орхиё.

Судлаачдын бичиж тэмдэглэснээс үзвэл 1912-1913 оны Монгол улсын эдийн засгийн байдлыг бүрэн гүйцэд төсөөлөх боломж тун бага байдаг бололтой. Гэхдээ

¹³ Клаузевиц К. О войне. Пер. с нем. – А.Рачинского. Москва: 1994, 27

¹⁴ *Военные поучения фельдмаршала графа Мольтке*. Переводъ съ нѣмецкаго фонъ Дитмана и Шнейдемана. С-Петербургъ: 1913, 3, 4

¹⁵ *Военная наука*. Теоретический труд. Под ред. И.Н.Родионова. Москва: 1992, 34

Монгол улс 1912 оны 5-р сард Хаант Орос улсаас 100000 рубль зээлж авсан бол удаах 1913 оны 1-р сарын 15-нд үзэглэсэн гэрээ ёсоор 2 сая целковыг зээлдэн авахаар тохирсон ч үүнээс урьд авсан зэвсгийн үнэд 311110, харин 1900 хүнтэй бригад байгуулах зардалд 350000 рублийг суутгах болсон гэдэг.¹⁶ Харин Монголын эрх баригчид дөнгөж 1913 оны хавраас Халхын дөрвөн аймагт ноогдуулах албан татварын хэмжээг хэлэлцэн тогтоосон бөгөөд үүнд 700 мянган лан мөнгө цуглуулах ёстой болсон боловч үүнээс 1914 оны эх хүртэл дөнгөж 25 орчим хувийг цуглуулсан гэдэг. Тэгэхлээр үндсэндээ 1913 оны үед Монгол улс өмнөх оны зээлтэйгээ нийлүүлээд 2.1 сая орчим рублийг төвлөрүүлэхээс цэргийн хэрэгт 670 мянган рублийг (бараг нийт цугларсан төсвийн 32 орчим хувь) зарсан гэх зураглал харагдаж байна.^{17*} Бидний өгүүлсэн зүйлд таван замаар мордсон цэрэгт шууд зарсан хөрөнгө багтаагүй ба тодорхой баримт одоогоор олж үзээгүй бөгөөд цэргийн сарын цалин (9 лан), хоолны зардал (2 цэн) мөн таван замаар мордсон цэргүүд аливаа газарт хүрсэн хойно худалдан авах хүнсний малын үнэ^{18*} зэргээс үзвэл чамгүй зардалтайгаар байлдаж байсан нь тодорхой байна. Жишээлбэл, Найданжав, Чимэдцэрэн нарын захирсан 983 цэргийн хүнсэнд, Шилийн голын Хуучид зүүн засгийн хошуунаас эр үхэр 150 (3000 лан), үнээ 130 (1950 лан), гуна үхэр 102 (816-1000 орчим лан), хонь 1684 (3368 лан), ямаа 325 (325 лан) буюу нийтдээ 9459 лангийн зардал гаргаснаа Егүзэр хутагтад мэдэгдэж байжээ.¹⁹ Үүний дээр цэргийн хэрэглэж байгаа зэр зэвсгийн үнэ, сум галт хэрэгслийг тээвэрлэх, зөөвөрлөх зардал сүйтгэлийг нэмвэл дээрх төсөвийн 32 хувь гэдэг тоо үлэмж нэмэгдэх байх. Энэ утгаараа 1913 оны түүхэн үйл явдлыг дайн гэж үзэж болно.

“1913 оны эхээр Өвөр Монгол руу хөдөлсөн цэрэгт Хүрээний цэргийн сургууль ба Халхын аймаг хошуудаас татсан цэрэг нэлээд тоогоор оролцсон ...”²⁰

¹⁶ Лонжид З. *Монгол улсын санхүүгийн албаны түүх* (1911-1921). Улаанбаатар: 2000, 12; Хишигт Н. Монголчууд тусгаар тогтнолоо олж үндсэний байнгын цэргээ байгуулахад Хаант Оросын зүгээс үзүүлсэн цэргийн тусламжийн асуудалд. *Studia Historica*. Tom. XXXI, fasc. 5. Улаанбаатар: 1999, 48

¹⁷ *Тухайн үеийн Монголын санхүүгийн байдлын тухай энэхүү зураглал (ер нь эхний удаагийн оролдлого гэж үзвээс зохилтой) нь ихээхэн хийсвэр болохыг дараах зүйлээр харуулья. 1911 оны билгийн улирлын өвлийн дунд сарын (1911.12.20 – 1912.1.18) үед Монголын Түр засгийн газраас (ө.х. XXГБХТЕЗШГазар) Улс төрийг тулгар зохиож хүү сан болгох учир дөрвөн аймгаас 8 түмэн лан татах ажлыг зохион байгуулж байжээ (Цэнджав Г. *Монгол улс дахь Хаант Оросын санхүүгийн зөвлөх түшмэлийн үйл ажиллагаа (1913-1916)*. Түүхийн ухааны доктор (Ph.D) зэрэг горилох бүтээл. Улаанбаатар: 2013, 48). Бид тооцоондоо үүнийг хамруулаагүй билээ.

¹⁸ * Эр хонь хоёр лан, эм хонь нэг лан таван цэн, эр ямаа нэг лан, эм ямаа найман цэн, шар үхэр хорин лан, үнээ арван таван лан.

¹⁹ Пунцагноров Ц. *Монголын автономит үеийн түүх*. Улаанбаатар: 1955, 63-64

²⁰ Жамсран Л. *Монголын сэргэн мандалтын эхэн* (1911-1913). Улаанбаатар: 1992, 99

болохыг манай эрдэмтэд хэлсээр ирсэн. Харин 1912-1913 оны үед Монгол улс багцаагаар таван зуун мянган хүн амтай байсан хэмээн үзвэл хүн амын нэлээд хувийг ялангуяа эрчүүдийн зонхилох хувийг лам нарын давхраа эзэлж байсныг бүгд мэднэ. Үүний дээр тайж, ноёд язгууртнууд болон өдөр бүр өсөн нэмэгдэж байсан шавь нарыг нэмвэл цэргийн алба хаах насны эрчүүдийн тоо илт бага гарна. Гэтэл 1913 онд Монгол улс таван замын цэргээс гадна халхын дөрвөн аймаг, дөрвөдийн хоёр аймгаас ойролцоогоор 9500 орчим цэрэг татаж Нийслэл Хүрээ, Улиастай, Ховд, Цагаан түнгэ зэрэг газарт суулгасан байдаг. Үүн дээр таван замын цэргийг нэмбэл 1913 оны намар гэхэд Монгол улсад цэргийн данстай эрсийн нэг түм дөрвөөс-таван мянгад хүрч байсан бололтой.

Халхын дөрвөн аймгаас дайны цагт 17450 цэрэг дайчлах ёстой ч үнэндээ дурын суман цэрэгт тохирох зөвхөн 25-40 тооны эр дайнд мордуулна гэсэн Ю.Кушелев-ийн судалгааг дагавал 4362-6980 цэрэг дайчлагдана, харин И.М.Майскийн судалгаагаар Халхад 18-50 насны 95.2 мянган эр цэргийн дансанд төөлөгдөх ёстой. Үүнээс мөн насны 16065 хамжлага, 2661 тамгатай хутагтуудын шавь, Их шавийн 3223, түүнчлэн 42.4 мянган лам болон тайж ноёд нийлсэн 5400 орчим язгууртан, мөн язгуургүй хэмээн үзсэн 6500 орчим аль ч давхраанд үл хамрагдах эрчүүдийг хасвал цэргийн алба хаах ёстой 18.9 мянган эр үлдэж байна.²¹ Чингэхлээр Монгол улс 1913 онд өөрийн хүн амын ялангуяа цэргийн насны алба хаах чадвартай эрчүүдийнхээ нөөцийг нэлээд шавхсан хэмжээнд ашигласан гэж үзэж болох л юм. Энэ нь эргээд 1913 оны үйл явдлыг дайн байсан гэж хэлэх бололцоог олгож байна. Өөрөөр хэлбэл, дээр товч өгүүлсэн ганц нэгэн зүйлээс үзвэл Монгол улсын ЦХБЗШЯамнаас олноо өргөгдсөний хоёрдугаар оны өвлийн сүүл сарын арван найманд (1913.1.24) айлтгасан бичиг ёсоор мордож мөн яамны олноо өргөгдсөний гуравдугаар оны арван нэгэн сарын шинийн долооны (1913.12.4) бичиг ёсоор хойш ухарч, татан буугдсан²² монгол цэргийн Өвөрмонголд Дундад иргэн улсын цэргийн эсрэг явуулсан 286 хоног буюу арван сарын үйл ажиллагааг дайн байжээ гэж үзэх сэжүүр нэмэгдэж байна гэсэн үг юм.

1913 онд Монгол ба Дундад иргэн улс яагаад дайн байлдаан хийх болсон шалтгааны талаар дараах цөөн зүйлийг хэлэхийг хүсч байна. Монголчуудын хувьд

²¹ Кушелев Ю. *Монголия и монгольский вопрос*. С-Петербург: 1912, 32; Майский И. *Орчин үеийн Монгол. Автономит Монгол XX зууны гараан дээр*. Улаанбаатар: 2001, 35, 39, 41, хавсралт 1, 2, 5, 8, 10

²² *Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл*. Баримт бичгийн эмхтгэл (1911-1914). Эмхтгэсэн А.Очир, Г.Пүрэвэ, тайлбар бичсэн А.Очир. Улаанбаатар: 1982, 223-226, 231-232

тусгаар тогтнол, улс орноо нэгтгэх зорилгоос шалтгаан үүссэн мэдээж бол ДИУ-ын хувьд монголчуудын тусгаар тогтнолыг устгах эрмэлзэл нэг шалтгаан байсан нь хэнд ч ойлгомжтой. Үүн дээр бид дараах зүйлийг нэмж хэлмээр байна.

Хорьдугаар зууны эхэн үеийн олон улсын хүчний харьцаанд Монгол орон тодорхой байр суурь эзлэх болсон нь гадаад гүрнүүдээс Монголд хандуулсан анхаарлаас харагдана. Тухайлбал, 1906 онд оросууд Өргөөд байдаг ерөнхий консулдаа монгол ноёдтой тогтоосон холбоо, харилцаагаа улам зузаатгах, ялангуяа Хутагт, түүний тойрон хүрээлэгчидтэй нягт хамтран ажиллах ёстойг сануулах болжээ.²³ Мөн Монголд ажилласан Оросын олон экспедиц дотор Хаант Оросын засгийн газрын дэмжлэгтэй Монголын цэрэг-стратегийн ач холбогдлыг үнэлэх, судлах зорилготой цэвэр цэргийнхний толгойлсон хээрийн шинжилгээний ангиуд ирж судалгаа явуулах давтамж 1905 оноос хойш эрс нэмэгдсэн нь дээр өгүүлсэн зүйлийг гэрчлэх нэг баримт мөн.²⁴ 1911 оны 5-10-р сард Монгол болон хил залгаа нутгаар 4216 мод газар (4497.5 км) аялсан Ю.Кушелев “Монгол нь газарзүй, байрзүй, уур амьсгалын язгуур шинж байдал, өргөн уудам газар нутаг, хүн амын төрөлх мөн чанараараа биднийг олон жил унтаа байсан Хятадаас мөн сэрчихээд зэвсэглэж буй Хятадаас найдвартай хамгаалах халх, бамбай байсаар ирсэн, цаашид ч байх болно” хэмээн бичсэн байдаг.²⁵ Ийм санааг урьд өмнө ч хэлж байв. “Бүр 1905 онд Монголоор аялсан Оросын Жанжин штабын ахмад В.Попов “Сибирьтэй хил залгаа Монгол орны цэргийн ач холбогдлыг ихээхэн өндөр үнэлж, Оросын хувьд онцгой чухал тэрхүү нөхцөл байдлыг алдахгүйн тулд зөвхөн улс төр, дипломатын төдийгүй цэргийн хувьд ч оролцоо буй болгох, тухайлбал манжийн үеийн монгол цагдааг европын цэргийн хүч болгохын тулд сайтар бэлтгэгдсэн сургагч нарыг Монголд илгээх, жил бүр хошуу нутагт цэргийн сургалт явуулах, зэвсэг хэрэгсэлийн нөөц буй болгох” санал дэвшүүлж байжээ.”²⁶

Монголчуудын оршин амьдарч байсан орон зайд XX зууны эхнээс их гүрний статустай нэгэн тоглогч нэмэгдсэн нь Япон юм.

²³ Урангуа Ж. *Монголын тусгаар тогтнолд Хаант Оросын үзүүлсэн хүчин зүйлс* (1911-1917 он). Улаанбаатар: 2010, 101

²⁴ Хишигт Н. Монголо-российское сотрудничество в военной области (1911-1916 гг.). *Россия и Монголия: Новый взгляд на историю взаимоотношений в XX веке*. Москва: 2001, 32; Хишигт Н. Монголчууд тусгаар тогтнолоо олж үндсэний байнгын цэргээ байгуулахад Хаант Оросын зүгээс үзүүлсэн цэргийн тусламжийн асуудалд. *Studia Historica*. Tom. XXXI, fasc. 5. Улаанбаатар: 2001, 46

²⁵ Кушелев Ю. *Монголия и монгольский вопрос*. С-Петербург: 1912, 3

²⁶ Хишигт Н. Монголчууд тусгаар тогтнолоо олж үндсэний байнгын цэргээ байгуулахад Хаант Оросын зүгээс үзүүлсэн цэргийн тусламжийн асуудалд. *Studia Historica*. Tom. XXXI, fasc. 5. Улаанбаатар: 2001, 46

XIX зууны ная, ерээд оноос Японы гадаад бодлогын чухал чиглэл нь Азийн эх газар Манжийн эзэрхийлж буй Хятад, Солонгос зэрэг орнууд болжээ. Манжуурыг эрхэндээ оруулахын төлөө Оростой өрсөлдөж эхэлсэн нь алсуураа Монголыг хамрах болсон гэж манай судлаачид үзсэн байдаг. Ялангуяа 1904-1905 оны дайнд Оросыг ялж, өрнөдийн гүрнүүдтэй нэгэн зиндаанд “их гүрний дамжаа” төгссөн Япон улс Хаант Оростой байгуулсан 1907, 1912 гэрээгээр Өвөрмонголын зүүн хэсгээр ашиг сонирхолынхоо бүсийг өргөтгөж чаджээ. Ингээд зогсохгүй японы талаас туршуул, тагнуул илгээх нь ихэссэн байна. Тухайлбал, Оросын хилийн албаны эрх бүхий этгээдээс 1904-1907 оны Монголын ард иргэдийн санаа бодол, улс төрийн нөхцөл байдлын тухай өгүүлж, дээш өргөсөн лавлагаанд “тун саяхан Өргөө (Урга) рүү японы хоёр тагнуул орон нутгийн хэл, аялгуу судлаж буй оюутан нэрээр очиж ажиллаад ирсэн” тухай тэмдэглэсэн байдаг.²⁷

Манж үндэстний байгуулсан улс өөр өөрийн гэсэн онцлог, уламжлалаа хадгалсаар ирсэн хэд хэдэн хэсгээс^{28*} бүрэлдэн тогтож байсныг бид бүгд мэднэ. Гэтэл XVIII зууны сүүл XIX зууны эхэн үеэс эхэлсэн хятад үндэстний хүн амын тэсрэлт, Манжийн төрийн хэрэгт өдрөөс өдөрт өсөн нэмэгдсээр байсан хятад түшмэдийн оролцоо, хятад маягийн соёлын давамгайлал нь XIX зууны дунд үе гэхэд Манж Чин улсын нүүр царайг XVII, XVIII зууны Манж улсаас эрс өөр төрхтэй болгосон тул гадныхан Манж бус харин Хятад гэж нэрийдэх явдал ихэссэн хэмээн үзэж болох юм. Харин Монгол мэтийн Манжийн бүрэлдэхүүн болж байсан улс төрийн өвөрмөц төлөв байдалтай нэгжүүд хятад ба манж нарыг тусдаа гэж хуучин ёсоор үзсээр ирсэн. Өөрөөр хэлбэл, XIX зуун сүүл XX зууны эхэнд Чин улсыг хуучин уламжлалаар Манж улс гэж тооцогч нэг хэсэг байхад хэдийнээ хятадын улс болсон гэж үзэгчид бас нэмэгдсээр байсан гэж болох юм. Зарим нэг утгаараа хятадууд үүнд багтах болов уу, учир нь 1912 оны эхээр туурга тусгаарласан хятад үндэстэн өөрсдийг нь эзэрхийлж асан улсаа өөрсдийнх нь улс байсан мэт аашлаж эхэлсэн нь ийн үзэхэд эрхгүй хүргэнэ.

Чингэхлээр судалгааны эргэлтэнд байгаа материалаас ганц нэгийг нь л авч үзэхэд лав 1912\13 он хүртэлх арваад жилийн хугацаанд Монголыг Хаант Орос, Япон, Манж Чин-ДИУ гэсэн гурван этгээд улс төр-цэрэг, эдийн засаг, газарзүйн байрлалын хувьд нухацтай сонирхож дор бүрнээ өөрийн мэдэлд оруулах зорилго агуулсан бодлого хэрэгжүүлж байжээ. Түүнчлэн энэ хугацаанд Монгол орон

²⁷ Батбаяр Ц. *Монгол ба Япон XX зууны эхэн хагаст* /Монголын улс төрийн гадаадын харилцааны түүхээс/. Улаанбаатар: 1998, 5, 24-26; Урангуа Ж. *Монголын тусгаар тогтнолд Хаант Оросын үзүүлсэн хүчин зүйлс* (1911-1917 он). Улаанбаатар: 2010, 96

²⁸ «Жинхэнэ» Хятад орон, Түвэд, Шинжаан, Манж нарын уугуул нутаг Манжуур болон Монгол.

цэргийн утгаар хүч сул нэгэн байсан. Энэ нь цэргийн хүч чадлын хувиар сул хэмээн тооцогддог мөн хүчирхэг улсуудын хүрээлэлд оршдог улс орон ямагт дайн хийх аятайхан бай болсоор ирсэн хэмээн Германы фельдмаршал Кольмар фон дер Гольцийн хэлсэнтэй зарим талаараа тохирдог.²⁹ Эдгээр нөхцөл байдал нь эргээд 1913 онд Монгол болон ДИУ зэвсэг зөрүүлэх нэлээд алсуур шалтгаан нөхцөл, дэвсгэр нь болсон болов уу.

1913 оны таван замын цэргийн түүхтэй холбоотой бас нэг хөндвөл зохих асуудал нь зэвсэгт мөргөлдөөнийг явуулж байсан арга, үйл ажиллагааны шинж чанарын тухай асуудал байх ёстой. Манай судлаачдаас энэ тухайд хэлсэн саналууд байдаг. Тухайлбал, монгол цэргийн байлдааны арга ажиллагааны шинж чанарын тухайд цэргийн түүхч Ж.Базарсүрэн, таван замын цэргийн хэрэглэж байсан байлдааны ов мэх, арга нь “уламжлалт морьт цэргийн урлаг зонхилсон хэвээр байсан” гээд голомтын чанартай төвүүдэд болсноор онцлог бөгөөд орчин үеийн ойлголтоор “жижиг дайны шинжтэй ч гэмээр байна”³⁰ гэж бичсэн байна.

Харин Хаант Орос Улсын Эрхүүгийн цэргийн тойргоос эрхэлж бүс нутгийн цэрэг-улс төрийн байдлын тухай мэдээ баримт нийтэлдэг “Дальний Востокъ” хэмээх сэтгүүлд нийтэлсэн материалуудыг үзвэл монголчууд партизаны дайны маягаар байлдааны ажиллагааг өрнүүлж байна гэж хэд хэдэн удаа дурдсан байх юм. Жишээлбэл, монголчуудын явуулж буй “дайн цэвэр партизаны дайны шинж чанарыг агуулах болов”, “монголчууд одоо партизаны дайны хэлбэрт шилжлээ. ДИУ-ын цэрэг байнга байршлаа өөрчилдөг дайсантайгаа тэмцэж чадахгүй байна”, Хаалган хотод дахь хятадын цэрэг “монголын партизаны баг цэргүүдийн тактикийг судлан сургуулилж байна”³¹ гэсэн мэдээ цөөнгүй.

Таван замын дайныг тухайн үеийн цэргийн шинжээчид партизаны шинж чанартай гэж бичсэн ч ингэж дүгнэх нь бодит байдлаас нэлээд зөрж байна хэмээн бид үзлээ. Учир нь партизаны дайны шинж чанар үеэс үед өөрчлөгдөж байдаг ч нэг гол мөн чанар хадгалагдсаар байдаг гэнэ. Энэ нь партизаны дайныг явуулагчид болдаг эзэгнэж буй газар нутагт энгийн иргэд дунд нуугдаж үйл ажиллагаа явуулдаг цэрэгжсэн болон энгийн хүмүүсийн бүрдэл байдагт оршино. Гэтэл Монгол улс төрийн бодлогоор, бас ч үгүй тодорхой төлөвлөсөн байдалтайгаар

²⁹ Энциклопедия военной мысли. Под редакцией Питера Тоуреса. Перевод с английского Кирилла Савельева. Москва: 2002, 121

³⁰ *Хорьдугаар зууны Монгол цэрэг*. Улаанбаатар: 2001, 198, 203

³¹ Дальний Востокъ. №2, 14-го января 1913 г. Свѣдѣнія из періодической печати. Иркутскъ: 1913, 27; Дальний Востокъ. №26, 29-го июня 1913 г. Свѣдѣнія из періодической печати. Иркутскъ: 1913, 7, 9

дайныг ухамсартай удирдаж, төлөвлөж явуулсан. 1913 он 1-р сарын 27-ний айлтгалыг ёсоор болгосон бичигт “... их цэргийг таван замд анги хуваан мордуулж, газар орныг сэргийлэн хамгаалуулж, дайсныг тосон сөнөөлгөх явдлыг төлөвлөсөн нь болох ба үл болохыг хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад ...”³² гэсэн үгс буй нь дээрхийн нэг баримт мөн болов уу. Хоёрт, монгол цэргийн зохион байгуулалт аравт, тавьт, хороо гэсэн бүтэцтэй байсан ба бие дааж байлдаан тулалдаан явуулах нэгж нь хороо байсан бололтой. Энэ нь аль ч зэвсэгт хүчинд байдаг бүтэц зохион байгуулалттай адил байгаа тул монголчуудыг зүгээр партизанууд гэж нэрлэх нь эргэлзээтэй зүйл болж байгааг харуулах байх. Аливаа байнгын армийн адилаар монголчууд тодорхой хэмжээний арга, тактик хэрэглэж байсан нь уг дайн партизаны дайн байгаагүйн бас нэг гэрч болов уу. Хэд хэдэн удаагийн тулалдаанд монголчууд ХХ зууны эхэн үед дэлхийн улс орнуудын армид хэрэглэж байсан тактикийг хэрэглэсэн бол ДИУ-ын цэрэг ч ялгаагүй европ маягийн дайн аргыг хэрэглэж монголчуудыг ялж байсан баримт байна. Жишээ нь Хаалган хот орчимд байрлаж байсан монгол цэргийг довтолсон ДИУ-ын бригадын хурандаа Лю Фучжэнь-ий захирсан хороо цэрэг, монголын цэргийн эзэлсэн байрлалыг тойрон ар талаас нь довтлон ухраасан ба хятад цэргүүд тасралтгүй гал явуулж, монголчуудыг дүрэм ёсоор хориглолтод шилжүүлээгүй ялсан байдаг. Түүнчлэн 1913 оны зун, намрын заагаар Дамдинсүрэн Долнуур хавьд ирсний хойно хятадын цэрэг Долнуур хотод хүч хуралдуулах болсныг үзээд эхлээд Сумъяа гүний цэргийг, дараа нь Бавуужавын цэргийг татан авчирч хүчээ зузаатгасан байдаг бол Чамухунь гэдэг газарт дайсны давуу хүчинд довтлуулж буй өөрийн цэрэгтээ монголчууд нэмэлт хүчийг илгээсэн баримт байдаг. Энэ мэт цөөн баримтаас харвал партизаны шинжтэй гэж хэлэх боломж бага л юм.

Мөн таван замын байлдааныг уламжлалт морьт цэргийн урлаг зонхилсон, голомтын чанартай төвүүдэд болсноор онцлог бөгөөд орчин үеийн ойлголтоор “жигжиг дайны” шинжтэй хэмээн дүгнэснийг мөн нягталж үзэх шаардлагатай. Бидний бодоход асуудлын аль өнцгөөс нь харснаас шалтгаалах болов уу. Монголын эдийн засгийн нөхцөл байдал хүндрэлтэй, түүнийг судлах баримт дутмаг, бодит байдлын дүр зургийг бүрэн гүйцэд гаргаж чадаагүй байгаа нь 1913 оны таван замын цэргийн түүхийн зарим асуудлыг шийдвэрлэхэд тодорхой нөлөө үзүүлж байна. Түүнчлэн мөн дайны бүх үеийн үйл ажиллагааны бүрэн зураглал

³² *Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл*. Баримт бичгийн эмхтгэл (1911-1914). Эмхтгэсэн А.Очир, Г.Пүрэвэ, тайлбар бичсэн А.Очир. Улаанбаатар: 1982, 223

гарч байж сая Монгол ба ДИУ-ын хооронд болсон энэхүү зэвсэгт мөргөлдөөний тодорхойлолт зөв эсэхийг нэгмөр шийдвэрлэвэл зохилтой мэдээж. Гэхдээ эх орны түүхийн судалгааны өнөөдрийн түвшин 1913 оны таван замын цэргийн үйл ажиллагаа зүгээр нэг байлдаан байгаагүй, харин томоохон, далайцтай дайн байсан гэж үзэх бололцоог олгож байна хэмээн үзэхэд буруудахгүй байх.